

БАТЛАВ.  
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕЙН  
ТАМИР, СПОРТЫН ХОРООНЫ  
ДАРГА

2017 он 05 сар 29 өдөр

Ж. ГАНБОЛД

БАТЛАВ.  
МОНГОЛЫН ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙ НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА

2017 он 05 сар 29 өдөр

С. ГАЛБАДРАХ

Ажил гүйцэтгэх гэрээ

2017 оны 05 дугаар сарын 27

№.....

Улаанбаатар хот

Нэг талаас Нийслэлийн Нийтийн Биеийн тамир, спортын хороо (цаашид “Захиалагч” гэх)-г төлөөлж, Спортын хөгжлийн хэлтсийн дарга С.Саранцэцэг, нөгөө талаас Монголын ширээний теннисний холбоо (“Гүйцэтгэгч” гэх)-г төлөөлж ерөнхий нарийн бичгийн дарга С.Галбадрах нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр Биеийн тамир, спортын тухай хуулийн 4.2.3 дахь заалт, Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хороо, Монголын Ширээний теннисний холбоотой хамтран “Улаанбаатар хот – 378 жил” олон улсын ширээний теннисний тэмцээнийг 2017 оны 06 дугаар сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулах.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын төлөөлөгчид болон албаны хүмүүсийг хамтран зохион байгуулж байгаа олон улсын тэмцээний нээлт, хаалт болон бусад албан ёсны үйл ажиллагаанд урьж оролцуулах.

2.2. Нийслэлийн Нийтийн биеийн тамир спортын хороотой хамтран зохион байгуулж байгаа “Улаанбаатар хот-378 жил” Олон улсын ширээний теннисний тэмцээний медаль, өргөмжлөлийн загварыг харилцан тохиролцож баталгаажуулах ба батлагдсан загварын дагуу үйлдэх.

2.3. Тэмцээн хамтран зохион байгуулсан арга хэмжээнүүдийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллээр сурталчлахдаа хамтрагч байгууллагын нэрийг дурдах ба Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны сайтад байршуулах /[www.sport.ub.gov.mn](http://www.sport.ub.gov.mn), [facebook.com, UB TAMIR/](https://www.facebook.com/UB.TAMIR/).

2.4. Тэмцээний заавар, хөтөлбөр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хамтран боловсруулж, баталгаажуулан хэрэгжүүлэх.

2.5. Хамтран зохион байгуулж байгаа үйл ажиллагааны албан баримтанд төрийн захиргааны байгууллагын хувьд эхэнд бичигдэнэ.

2.6. Гүйцэтгэсэн ажилд ямар нэгэн доголдол байвал гомдлын шаардага гаргах эрхтэй.

2.7. “Гүйцэтгэгч”-ээс тухайн тэмцээнтэй холбогдох бичиг, баримт, материалуудыг шаардаж авах эрхтэй.

2.8. “Гүйцэтгэгч”-д үүргээ биелүүлэхэд шаардагдах бичиг баримт болон бусад холбогдох мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

2.9. “Гүйцэтгэгч”-ийн гүйцэтгэсэн ажлын төлбөрийг саадгүй төлөх үүрэгтэй.

Гурав. Ажил гүйцэтгэгчийн эрх, үүрэг

3.1. Тэмцээний заавар, хөтөлбөр, бэлтгэл ажлын төлөвлөгөөг хамтран боловсруулж, баталгаажуулан хэрэгжүүлэх.

3.2. Тэмцээнд баг тамирчдыг өргөнөөр хамруулах, тэмцээн явуулах зар мэдээллийг хүргэх.

3.3. Тэмцээн зохион байгуулахад шаардагдах тоног төхөөрөмж, хэрэглэлийг хангах, бүрдүүлэхэд тусалж ажиллах, шүүгчдийн бүрэлдэхүүнийг томилох.

3.4. Ажил гүйцэтгэхийн өмнө “Захиалагч”-аас хийгдэх үнэ төлбөрийг зөвшилцсөн байна.

3.5. Тэмцээн хамтран зохион байгуулсан арга хэмжээнүүдийн тухай мэдээллийг хэвлэл мэдээллээр сурталчилахдаа хамтрагч байгууллагын нэрийг дурдах ба Нийслэлийн Нийтийн биеийн тамир, спортын хорооны [it@sport.ub.gov.mn](mailto:it@sport.ub.gov.mn), [facebook.com/UB.TAMIR](https://www.facebook.com/UB.TAMIR) хаяг руу мэдээллийг түргэн шуурхай илгээж байх

3.6. “Гүйцэтгэгч” байгууллага нь тухайн тэмцээн дууссанаас хойш ажлын 7 хоногт багтаан гүйцэтгэсэн ажилтай холбогдох баримт бичиг, материалуудыг бүрдүүлж тайлан мэдээг захиалагч талд бүрэн хүлээлгэж өгөх үүрэгтэй.

3.7. Гэрээнд заасан ажлыг захиалагчийн өгсөн саналын дагуу тогтоосон хугацаанд нь чанартай хийж гүйцэтгэх үүрэгтэй.

#### Дөрөв. Ажлын төлбөр

4.1. Гэрээгээр гүйцэтгэх ажлын төлбөр болох 6.000.000 /зургаан сая/ төгрөгийг “Захиалагч” байгууллага нь тэмцээн зохион байгуулахаас өмнө зохих журмын дагуу “Гүйцэтгэгч” байгууллагын дансаар төлбөрийг бүрэн төлнө.

#### Тав. Талуудын хүлээх хариуцлага

5.1. Гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, зохих ёсоор биелүүлээгүйгээс учруулсан хохирлыг гэм буруутай тал нь хохирогч талдаа нөхөн төлөх үүрэгтэй.

5.2. Торгууль, алданги төлсөн материалыг устгасан, гэмтээснийг нөхөн төлөх үүрэг гүйцэтгэхээс чөлөөлөгдөхгүй.

#### Зургаа. Бусад заалт

6.1. Гэрээ байгуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно. (Эсвэл хүчин төгөлдөр болох өдрийг тохиролцож болно)

6.2. Гэрээний хугацаа, нөхцөл байдлын талаар өөрчлөлт оруулахаар бол хоёр тал харилцан тохиролцож нэмэлт нөхцөлөөр шийдвэрлэнэ.

6.3. Хэрэв талуудын хооронд маргаан гарвал талууд үл маргах журмаар шийдвэрлэх ба маргаанаа шийдвэрлэж чадахгүйд хүрвэл (шүүх, арбитра)-аар шийдвэрлүүлнэ (доогуур нь зур).

#### Долоо. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах журам

7.1. Ажил гүйцэтгэх явцад гэрээнд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт нь зөвхөн бичгээр хийгдэж талуудын гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

7.2. Учруулсан хохирлыг арилгахтай холбогдсон хууль тогтоомжид заасан үндэслэлээр 2 тал харилцан тохиролцож гэрээг хугацаанаас нь өмнө цуцалж болно.

#### Найм . Нэмэлт нөхцөл


.....  
.....  
.....

#### ГЭРЭЭНИЙ БАТАЛГААЖУУЛАЛТ:

ЗАХИАЛАГЧ:  
НИЙСЛЭЛИЙН НИЙТИЙН БИЕИЙН  
ТАМИР, СПОРТЫН ХОРООГ ТӨЛӨӨЛЖ:  
СПОРТЫН ХӨГЖЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА

  
С.САРАНЦЭЦЭГ  
Холбогдох утас: 91915546

ГҮЙЦЭТГЭГЧ:  
МОНГОЛЫН ШИРЭЭНИЙ ТЕННИСНИЙ  
ХОЛБООГ ТӨЛӨӨЛЖ:  
ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

  
С.ГАЛБАДРАХ  
Холбогдох утас: 99156872